

## ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл болон дагаж гарах хууль, тогтоолын төслүүдийг хуулийн төслийн үзэл баримтлал, Хуулийн тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлсэн боловсруулж, олон нийтээс ирүүлсэн саналыг тусган боловсруулсан болно.

Нэг.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийг 5 бүлэг 25 зүйлтэй байхаар боловсруулсан.

№	Бүлэг	Зүйл	Танилцуулга
1	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 2 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомж 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо 5 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтад баримлах бодлого, зарчим 6 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалт хийх хүрээ 7 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг	<p>1.Хуулийн төслийн нэрийг “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” гэж нэрлэнэ. Ингэхдээ олон улсын сайн туршлага, улс орны эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалтын өсөн нэмэгдэх оролцоо, эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулах шаардлага бий болсныг харгалзан үзнэ.</p> <p>Олон улсын жишгээс харахад хөгжиж байгаа улсуудын ихэнх нь ГШХО-ын тухай хуультай байна. Тухайлбал, НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурал (UNCTAD)-ын улс орнуудын хөрөнгө оруулалтын хуулиудыг харьцуулсан судалгаагаар хамгийн багадаа 108 улс хөрөнгө оруулалтын хуультай болохыг тогтоожээ. Эдгээр хуулиудын 58 хувь (64) нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг, бусад нь зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтыг тусгайлан хуультай байна. Ялангуяа Азийн орнууд гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай байдаг бол Африкийн ихэнх улс орнууд хөрөнгө оруулалтын ерөнхий хуулийг баталсан байдаг.<sup>1</sup></p> <p>2.Нийтлэг үндэслэл бүлэгт хуулийн зорилт, нэр томьёоны ойлголт, хөрөнгө оруулалтын бодлого, зарчим, хүрээ, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлно.</p> <p>- НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын хөрөнгө оруулалтын орчны мэдээллийн санд буй 124 оны хөрөнгө оруулалтын хуулийн зорилго, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, хуулийн төсөлд ирүүлсэн саналд үндэслэн хуулийн төслийн зорилтыг Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг гадаадын шууд хөрөнгө оруулалтад түшиглэн дэмжих, Монгол</p>

<sup>1</sup> [https://unctad.org/system/files/official-document/webdiaepcb2016d5\\_en.pdf](https://unctad.org/system/files/official-document/webdiaepcb2016d5_en.pdf)

			<p>Улсын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, урамшуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар заасан.</p> <p>3.Хуулийн төслийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах гадаадын хөрөнгө оруулалтад хамаарахаар тодорхойлсон.</p> <p>4.Хуулийн төсөлд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд гэсэн нэр томъёог тусгана.</p> <p>-Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьцааны 25, түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмших ба оруулах хөрөнгийн доод хэмжэг Засгийн газар тогтоохоор заав.</p> <p>-“хөрөнгө оруулалтыг дэмжих” (investment promote) гэсэн томъёоллыг олон улсад хэрэглэгддэг агуулгын дагуу тодорхойлсон.</p> <p>-“үндэсний таатай нөхцөл” ойлголтоор гадаадын хөрөнгө оруулагчдад олгох нөхцөлийг дотоодын хөрөнгө оруулагчид олгодог нөхцөлөөс дордуулахгүй байх, “сөрөг жагсаалт” гэсэн ойлголтын хүрээнд тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулалт оруулттай холбоотой зөвшөөрөл олгох, хориглох, хязгаарлах зэрэг эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийг ойлгохоор заасан.</p> <p>-гадаадын хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын болон татварын бус урамшуулал үүлэхтэй холбоотой татварын хувь хэмжээг тогтворжуулах, тогтворжуулах гэрчилгээний ойлголтыг</p> <p>5.Гадаадын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой, нээлттэй байдлыг хангах, төрийн бодлого, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, түүнчлэн олон улсын сайн туршлагыг харгалзан “Гадаадын хөрөнгө оруулалтад баримтлах бодлого, зарчим” гэсэн зүйл тусгасан. Үүнд гадаадын хөрөнгө оруулалтын нээлттэй, тааламжтай бодлого баримталж, тогтвортой, ил тод, урьдчилан таамаглахуйц, тэнцвэртэй орчныг бүрдүүлнэ. Гадаад хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинээр батлахад УИХ-ын гишүүд заавал хүрэлцэн ирэхийг заана.</p> <p>6.Гадаадын хөрөнгө оруулалтын сөрөг жагсаалтыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ батлах ба сөрөг</p>
--	--	--	---

			<p>жагсаалтад тусгагдаагүй гадаадын хөрөнгө оруулалтад үндэсний нөхцөл олгохоор тусгана.</p> <p>7.Төр гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгө, орлого, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.</p>
2	<p><b>Хоёрдугаар бүлэг</b> <b>Хөрөнгө оруулалтыг дэмжих</b></p>	<p>8 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтыг дэмжих төрийн чиг үүрэг</p> <p>9 дүгээр зүйл.Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны зөвлөлийн чиг үүрэг</p> <p>10 дугаар зүйл. Гадаад хөрөнгө оруулалт, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас үзүүлэх үйлчилгээ</p>	<p>“Хөрөнгө оруулалтыг дэмжих” бүлэгт гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого, дэмжлэг болон төрийн захиргааны байгууллага болон Зөвлөлийн чиг үүргийг тодорхойлно.</p> <p>8.Гадаадын хөрөнгө оруулагчид тодорхой салбарт гадны хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын хүрээнд давуу эрхийн хөнгөлөлт олгох, гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоолын төсөлд саналыг авсан байх, үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох зэрэг дэмжлэг үзүүлэх хэлбэрийг тодорхойлно.</p> <p>9.Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулагчид мэдээлэл, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар нэг цонхны цахим үйлчилгээ үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны мэдээллийн санг хөтлөх зэрэг чиг үүрэгтэй ажиллахаар тусгасан.</p> <p>10.Гадаадын хөрөнгө оруулалтын үндэсний зөвлөлийг төрийн болон хараат бус гишүүдийн төлөөллөөс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Засгийн газар байгуулна. Зөвлөлийг гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахлах ба хараат бус гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж, томилно. Зөвлөл нь гадаад хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, дүгнэлт гаргаж, Засгийн газарт санал оруулах, хөрөгө оруулалтын талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрт оролцох, гадаадын хөрөнгө оруулагчийн гомдлыг хянан шийдвэрлэх зэрэг чиг үүрэгтэй ажиллана.</p>
3	<p><b>Гуравдугаар бүлэг.</b> <b>Хөрөнгө оруулалтын хамгаалалт</b></p>	<p>11 дүгээр зүйл.Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийн баталгаа</p> <p>12 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны баталгаа</p>	<p>“Хөрөнгө оруулалтын хамгаалалт” бүлэгт Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийн болон үйл ажиллагааны баталгаагаар хангах зохицуулалтыг заана.Үүнд</p> <p>11.Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар дайчлан авахыг хориглох, зөвхөн нийтийн ашиг сонирхлын үүднээс хуульд заасан үндэслэл журмын дагуу нөхөн</p>

			<p>олговор олгох нөхцөлтэй дайчлан авч болох, орлого, ашгаа гадаад шилжүүлэх зэрэг хөрөнгийн баталгаагаар хангагдана.</p> <p>12.Гадаадын хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны баталгааны хүрээнд төрөөс хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хууль бусаар тогтоох аливаа хязгаарлалт, зохицуулалтыг хориглосон. Тухайлбал хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нэмэлт үүрэг хүлээлгэх, зах зээлд нэвтрэх, гарах нөхцөлийг тогтоох зэргийг хориглосон. Төр хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах, нийтийн эрх ашгийн үүднээс гэрээ, тогтворжуулах гэрчилгээнд өөрчлөлт оруулсан бол хөрөнгө оруулагч нь хохирлоо нөхөн төлүүлэх, гомдлоо хуульд заасны дагуу шийдвэрлүүлэх эрхээр хангагдана.</p>
4	<p><b>Дөрөвдүгээр бүлэг</b> <b>Хөрөнгө оруулалтын менежмент, урамшуулал</b></p>	<p>13 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг бүртгэх, зөвшөөрөл олгох 14 дүгээр зүйл.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хөрөнгийн хэмжээ 15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын урамшуулал 16 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын татварын бус урамшуулал 17 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын татварын хувь хэмжээг тогтворжуулах дэмжлэг 18 дугаар зүйл. Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур 19 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ 20 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах</p>	<p>“Хөрөнгө оруулалтын менежмент, урамшуулал” бүлэгт Гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой төрийн дэмжлэг, хяналт, зохицуулалтыг заахын хамт гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь Монгол Улсын хууль тогтоомжийг биелүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгана. Үүнд:</p> <p>13.Тусгай зөвшөөрөл авахад дотоодын хөрөнгө оруулагчийн нэгэн адил журам үйлчлэх, гадаадын хөрөнгө оруулалтын төслийг баталгаажуулах, бүртгэхэд хууль тогтоомийг баримтлах, үйл ажиллагаанд нь хийх төлөвлөгөөт хяналт шалгалт жилд 2-оос доошгүй байхыг заана.</p> <p>14.ГХОАА-ийн удирдлага, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт нь Компанийн хуульд нийцсэн байх, татвар, санхүү, тайлан бүртгэл, хөдөлмөр, нийгмийн хамгаалалтай холбоотой хуульд заасан чиг үүргийг биелүүлнэ.</p> <p>15.“Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд гадны хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгийн хэмжээг салбарын онцлогоос хамаарч Зөвлөлийн санал болгосноор Засгийн газар тогтоохоор заана.</p> <p>16.Хөрөнгө оруулагчид олгох татварын болон татварын бус дэмжлэг, урамшуулал, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах асуудлыг тодорхойлно. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах салбарын чиглэлийг УИХ батална.</p> <p>Энэ хуульд заасан шалгуур, гэрээний нөхцөлийг хангасан бол дотоодын хөрөнгө оруулагч нь тогтворжуулах гэрчилгээ олгох,</p>

			<p>хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой болохыг заана.</p> <p>17.Татварын бус урамшуулалд ажиллах хүчний зөвшөөрөл, ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, улсын бүртгэлийн асуудал, оршин суух зөвшөөрөл зэрэг үйл ажиллагаа явуулахад үзүүлэх урамшууллыг хамруулсан.</p> <p>-Тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын хувь хэмжээ тогтворжуулах дэмжлэгийг олгохоор заасан. Энэ хүрээнд 4 төрлийн татварыг тогтворжуулах одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн. Гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулсан татварын хэмжээг бууруулсан бол энэ өөрчлөлт хамаарна.</p> <p>-Тогтворжуулах гэрчилгээг 30 хүртэлх жилээр олгох ба гэрчилгээ олгох шалгуурыг Засгийн газар батлахаар заасан.</p> <p>18.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, тавигдах шаардлага, гэрээ байгуулах, хяналт тавихтай холбоотой журмыг Засгийн газар батална. Гэрээг 30 хүртэлх жилийн хугацаагаар байгуулж болохоор тусгасан.</p>
5			<p>“Бусад” бүлэг-т хөрөнгө оруулагчийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, хууль зөрчигчид хүлээлгэх харицлага, хуулийг дагаж мөрдөх зохицуулалтыг тусгана.</p>
6	<p><b>Тавдугаар бүлэг Бусад</b></p>	<p>21 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулагч гомдол гаргах, гомдлыг хүлээн авах</p> <p>22 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын маргаан</p> <p>23 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>24 дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт</p> <p>25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох</p>	<p>19.Гадаадын хөрөнгө оруулагч эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзвэл гомдлоо гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны зөвлөлд гаргаж болно.</p> <p>-Зөвлөл нь шийдвэр гарган, холбогдох төрийн байгууллагад үүрэг чиглэл өгөх ба шийдвэрийнхээ биелэлтийг Зөвлөл, Засгийн газар тухай бүр сонсож хэлэлцэж байна.</p> <p>20.Гадаадын хөрөнгө оруулагч, төрийн байгууллагын хооронд үүсэх хөрөнгө оруулалтын маргаан, гадны хөрөнгө оруулагч болон иргэд, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргаантай холбоотой зохицуулалтыг тусгана.</p> <p>Төр, гадаадын хөрөнгө оруулагчийн хооронд үүссэн маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол олон улсын арбитраар шийдвэрлүүлэхээр заасан.</p> <p>21.Хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх болон хууль хүчин төгөлдөр болох заалтыг тусгасан.</p> <p>Хууль хүчин төгөлдөр болсноор өмнөх хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан</p>

			этгээдийн эрх ашгийг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгасан.
--	--	--	--

**Хоёр.**Хуулийн төслийг дагаж нийт 17 хуульд өөрчлөлт оруулах, 1 хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, 1 УИХ-ын тогтоолыг төслийг тус тус боловсруулна. Үүнд:

1.Хууль хүчингүй болсонд тооцох тухай  
УИХ-аас 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийг хүчингүй болгоно.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах, үүнд бүртгэх хугацааг дотоодын хөрөнгө оруулагчтай ижил байх, бүртгүүлэхэд шаардлагагүй зарим баримт бичгийг бүрдүүлэхээр заасныг хасах зэрэг өөрчлөлтийг тусгана.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд төлөх тэмдэгтийн хураамжийн хэмжээг дотоодын хөрөнгө оруулагчтай нэгэн адил байхаар өөрчилнө.

4.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Цөмийн энергийн комисоос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах зохицуулалтыг хүчингүй болгоно.

5.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай

Хуулийн төсөлд заасан гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үйл ажиллагаанд жилд 2-оос илүүгүй төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулах заалттай уялдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд холбогдох нэмэлтийг тусгана.

6.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гадаадын хөрөнгө оруулагч иргэнд оршин суух зөвшөөрлийг олгохдоо давхар мэдээлэл шаардахгүй буюу хөрөнгө оруулалтын мэдээллийн санг үндэслэн олгож байх өөрчлөлтийг тусгана.

7.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих журам болон визийн хугацаа хэтрүүлсэн зөрчил гаргасан бол түүнд оногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлэн тогтооно.

#### 8.Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын хуулийн этгээд аудитын компани байгуулахад нийт хувьцааны гуравны нэгээс доошгүй нь Монгол Улсын иргэн, мэргэшсэн нягтлан бодогч эзэмшдэг байхаар заасныг хүчингүй болгоно.

#### 9.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын этгээд үнэлгээний хуулийн этгээд байгуулахад нийт хувьцааных нь гуравны нэгээс доошгүй нь Монгол Улсын иргэн үнэлгээчин эзэмшдэг байх, түүнчлэн үнэлгээний хуулийн этгээдийн хувьцааны гуравны хоёроос доошгүй хувийг үнэлгээний эрх авсан этгээд эзэмшдэг байх шаардлагыг хүчингүй болгоно.

#### 10.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Байгаль орчны нөлөөлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсын аж ахуйн нэгжид олгохоор заасныг хуулийн этгээдэд олгох байдлаар өөрчлөлт оруулна.

#### 11.Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Усны нөөцийн хайгуул судалгааны ажлыг эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид олгохоор заасныг хүчингүй болгох өөрчлөлт оруулна.

#### 12.Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Байгалийн ховор, элбэг ургамлыг эмийн үйлдвэрийн зориулалтаар тарималжуулан ашиглах үйл ажиллагаа эрхлэх нь зөвхөн дотоодын аж ахуйн нэгжид хамааралтай байхаар заасныг хүчингүй болгоно.

#### 13.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль өөрчлөлт оруулах тухай

Улсын чанартай томоохон төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийсэн бол гаалийн татвар төлөх хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлж болох хөнгөлөлтийг хөрөнгө оруулагч эдэлж болох бөгөөд энэхүү өөрчлөлтөөр үүнд хамаарах салбарын чиглэлийг тодорхойлно.

14.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Эшлэлийн дугаар өөрчлөгдсөнтэй холбоотой хууль зүйн техникийн шинжтэй өөрчлөлтийг тусгана.

15.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай

Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хэмжээгээр татвар төлөх заалтыг нэмж тусгана.

16.Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээг хавсаргахаар заасныг хасах өөрчлөлтийг тусгана.

17.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд нь уул уурхай, банк, санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээрх дотоодын аж ахуйн нэгжийн хувьцааны 33 түүнээс дээш хувийг худалдан авахтай холбоотой зөвшөөрлийн заалтыг хүчингүй болгоно.

18.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд төрөлжсөн банк байгуулах, хувьцаа худалдан авахтай холбоотой зөвшөөрлийн заалтыг хүчингүй болгоно.

19.Хуулийн хэрэгжилт хангуулах тухай УИХ-ын тогтоолын төсөл

Тогтоолоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хэдэн чиглэлээр арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгах бөгөөд үүнд хөрөнгө оруулагчийн хөрөнгийг дайчлан гаргуулсан бол нөхөн олговрыг олгох ажлыг зохион байгуулах, эрх ашгийг хөндсөн шийдвэрийн талаар талуудын саналыг авч байх, нөхөн төлбөрийг төсөвт тусган шийдвэрлүүлдэг байх зэргийг тусгана.